

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН  
2019 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.04.08

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 03 дугаар сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ мэдээ 203, урт хугацааны урьдчилсан мэдээ 126, районы урьдчилсан мэдээ 210, угталтын урьдчилсан мэдээ 152, өндрийн салхины урьдчилсан мэдээ 248, аэродромын урьдчилсан мэдээ 62, SIGMET 17, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF 62, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 202, Ханбумбат нисэх буудлын TAF 154, Овоот нисэх буудлын TAF 21, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 35 удаа тус тус гаргаж, олон улсын 681, орон нутгийн 414, онцгой ба тусгай үүргийн 16 нислэгийг 278 чиглэлийн урьдчилсан мэдээ болон бодит мэдээ 1364, уур амьсгалын ажиглалтын мэдээ 248, харьцуулсан ажиглалт 23, аюул 2, агаар мэдээ-2 мэдээ, мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтээр цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 5325 бодит мэдээ, 1790 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 3 дугаар сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. WAFS-ын бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Энэ сард нийт цаг агаараас шалтгаалсан 38 саатал гарсан байна. Үүнд: Урьдчилсан мэдээ таарсан 32, таараагүй урьдчилсан мэдээ 6, /2018 оны 3 сард нийт 14 саатал гарсан, таарсан 10, таараагүй 4 байсан байна/

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 1,99%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1.11%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Орон нутагт:**

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 264, бэлтгэл буудлын 651 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 130, угталтын урьдчилсан мэдээ 2, буудал орчмын бодит мэдээ 3359, буудал орчмын урьдчилсан мэдээ 1230, районы урьдчилсан мэдээ 471, аэродромын урьдчилсан мэдээ 336, зурвасын гадаргын байдлын

мэдээг 12 дамжуулж үйлчилсэн. Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 2 нислэгийн саатал гарсан бөгөөд Увсын Дэглий цагаан нисэх буудалд манантай байснаас нислэгийг чиглэл өөрчилсөн-1, хүлээсэн-1 нислэгүүд саатсан байна.

Агаарын тээвэрлэгч байгууллагууд болон нисэх буудлуудад хаврын улиралд ажиглагддаг шороон болон цасан шуурга шуурах, мөстөлт, сэгсрэлт үүсэх, шар усны үер, түймэр зэрэг нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй цаг агаарын нөхцөлүүдээс урьдчилсан сэргийлэх зорилгоор зөвлөмж бэлтгэн хүргүүлсэн.

Ус, цаг уурын албаны 95 жилийн ойд зориулан байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулах гэрэл зургийн үзэсгэлэн, видео мэндчилгээнд оруулах зураг болон бусад текст материалыг бэлтгэн ЦУОШГ-т хүргүүлсэн.

БОАЖЯ, ЦУОШГ болон ИНЕГ-ын бусад шагналд дэвшсэн албан хаагчдын ажил байдлын тодорхойлолт, холбогдох материалуудыг хүргүүлж, БОАЖЯ, ЦУОШГ-ын шагналаар-6, ИНЕГ-ын шагналаар 3 хүн шагнуулсан.

Төрийн албаны тухай шинэчилсэн хууль мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлыг хэлтэс, салбарын дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр “Албан тушаалын тодорхойлолтын маяг”-ын дагуу шинэчилж байна. Уг ажлын хүрээнд ажлын байрны шинжилгээний асуулгыг Төрийн албаны зөвлөлийн цахим хаяг болон цаасаар бөглөж, түүний дагуу ажлын байрны дүн шинжилгээ хийгдсэн.

ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас явуулсан ИНД-174-ийн “Нисэхийн цаг уурын үйлчилгээ эрхлэх байгууллагыг гэрчилгээжүүлэх” дүрмийн дагуу олгогдсон гэрчилгээг сунгах үзлэг шалгалтын зөвлөмж, шаардлагын дагуу төлөвлөгөө боловсруулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн ажлуудыг дүгнэж байна.

Шилэн дансны нэгдсэн системд 2019 оны 3 дугаар сарын байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн тушаал шийдвэрийн мэдээллийг оруулсан. Төвийн даргын А/06, А/08 дугаар тушаалуудыг (сургалтын төлбөр гаргах тухай) хавсралтын хамт оруулсан.

Сургалт дадлага, хурал, семинар:

Н.Мөнхбат	Синоптик инженер	Дундговь аймгийн УЦУОШТ	2019.02.22-03.08
М.Мөнх-Эрдэнэ	Синоптик инженер	Увс аймгийн УЦУОШТ	2019.02.22-03.13
Д.Цэнд-Аюуш	Техникч	Баянхонгор аймгийн УЦУОШТ	2019.02.22-03.11
Б.Мөнхжин	Техникч	Баянхонгор аймгийн УЦУОШТ	2018.02.22-03.11

“Үндэсний мэдээлэл технологийн академи” ТББ-д зохион байгуулагдаж буй компьютерийн практикт суурилсан Вэб мастер мэдээлэл технологийн сургалтад Сүлжээ, мэдээллийн сангийн инженер Ш.Аюушжавыг, программ хангамжийн мэдээлэл технологийн сургалтад А.Баярмаа нар 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай хамрагдаж байна.

Жижүүр цахилгаанчин А.Баярсайхан “Flash” санхүү, бизнесийн мэргэшсэн сургалтын төвд жижиг, дунд аж ахуйн нэгжийн няравын мэргэжил олгох 40 цагийн сургалтанд хамрагдсан.

**Дүгнэлт:**

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 3 дугаар сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төв